



Хэвлэлийн мэдээлэл No. 18/183  
ШУУД ТҮГЭЭХ  
2018 оны 5-р сарын 18

Олон Улсын Валютын Сан  
Вашингтон, К.Т. 20431 АНУ

**ОУВС Монгол улсад хэрэгжүүлж буй Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн дөрөв дахь үнэлгээг хийж, ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрлээ.**

Ажлын хэсгийн айлчлалын төгсгөлд гаргаж байгаа хэвлэлийн мэдээлэлд тухайн оронд ажилласан ОУВС-гийн мэргэжилтнүүдийн багийн урьдчилсан үр дүн дээрх дүгнэлтийг танилцуулж байна. Энд илэрхийлсэн байр суурь нь ОУВС-гийн мэргэжилтнүүдийн байр суурь бөгөөд ОУВС-гийн Захирлуудын зөвлөлийн байр суурийн илэрхийлэл байх албагүй юм. Ажлын хэсгийн үнэлгээний урьдчилсан дүгнэлтэнд үндэслэн тайлан боловсруулж, ОУВС-гийн удирдлагаар батлуулсны дараа Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлж, шийдвэр гаргуулна.

- Экспортын түүхий эдийн эрэлт их байгаагаас Монголын эдийн засгийн сэргэлт үргэлжилсээр байна; Төсвийн алдагдлыг бууруулах, гадаад валютын албан нөөцийг нэмэгдүүлэх зэрэг макро-эдийн засгийн гол зорилтууд биелжээ.
- Хэдийгээр ийм дэвшил гарсан ч экспортын түүхий эдийн эрэлт буурах, бүтцийн шинэчлэлийн удаашрал, дотоодын зарлага нэмэгдэх дарамт, хөрөнгө оруулалтын орчин дахь сөрөг өөрчлөлтүүд зэрэг эрсдэлүүд хөтөлбөрийн хүрээнд байсаар байна.
- Хөтөлбөрийг амжилттай үргэлжлүүлэхийн тулд банкны системийг бэхжүүлэх, төсвийн хянамгай бодлого баримтлах, инфляцид сонор сэрэмжтэй байх, эрсдэлээс хамгаалах гадаад валютын албан нөөцөө бүрдүүлэх, төсвийн санхүүгийн удирдлагыг сайжруулах зэргийг анхаарлын төвдөө байлгасаар байх шаардлагатай.

н.Жэф Готтлийбээр ахлуулсан Олон Улсын Валютын Сан (ОУВС)-гийн ажлын хэсэг 2018 оны 5-р сарын 2-17-ны өдрүүдэд Улаанбаатар хотод ажиллаж 2017 оны 5-р сарын 24-ний өдөр батлагдсан гурван жилийн хугацаатай Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн дөрөв дэх үнэлгээний яриа хэлэлцээг хийлээ. Уг хөтөлбөрийн хүрээнд нийтдээ 314.5054 сая ЗТЭ буюу ойролцоогоор 434.3 сая ам.долларын [1] зээл олгохоор анх тохирсон ([Хэвлэлийн мэдээлэл No. 17/193](#)-ыг харна уу).

Ажлын хэсгийн айлчлалыг дүгнэж н.Готтлийб дараах мэдэгдлийг хийв:

“Хөтөлбөрийн хүрээнд макро-эдийн засгийн гүйцэтгэл эерэг гарч бүх зорилтот тоон үзүүлэлтүүд биелсэн. Төсвийн үр дүн 2018 оны эхний улиралд төсөөлж байснаас илүү сайжирч, орлого 21 хувиар өссөн. Дээрх хугацаанд гадаад валютын цэвэр албан нөөц 200 сая ам.доллараар нэмэгджээ.

“Эрх баригчид 2018 оны төсвийн бодлогын хөтөлбөртөө төсвийн хязгаарлалт болон татварын удирдлагыг бэхжүүлэх ажлуудыг үргэлжлүүлэн хийхээр төлөвлөсөн байна. Түүнчлэн, эрх баригчид төсвийн санхүүгийн удирдлага, ялангуяа концесс, төсвийн хөрөнгө оруулалттай төслүүд, Монголын Хөгжлийн банкны үйл ажиллагааг сайжруулах тал дээр тодорхой алхмуудыг авч хэрэгжүүлж байна.

“Санхүүгийн салбарын хувьд эрх баригчид саяхан хийгдэж дууссан Активын чанарын үнэлгээний дагуу хийгдэж буй арга хэмжээний нэг хэсэг болох банкны системийг бэхжүүлэх ажлуудаа үргэлжлүүлж байна. Өөрийн хөрөнгийн шаардлагаа хангаагүй банкуудад энэ оны 12-р сарын эцэс хүртэл түүнийг хангах хугацаа байна. Зохистой нөхцөл бүрдсэн үед банкуудыг тогтворжуулахад төсвийн сангуудыг ашиглаж болох талаарх хууль удахгүй батлагдана гэсэн хүлээлттэй байна. Эрх баригчид чанаргүй зээлийн асуудлыг илүү хурдан шийдвэрлэх тогтолцоог бүрдүүлэх шинэчлэлийг хийж, банкуудын балансыг сайжруулахаар мөн ажиллаж байна.

“Эрх баригчид инфляцид сэрэмжтэй байж, төлбөрийн тэнцлийг цаашид улам бэхжүүлэх мөнгөний бодлогын байр сууриа хадгалах үүрэг хүлээсэн. Эдийн засгийг гадаад цочролоос хамгаалахад тус нэмэр болох нөөцийн бүрдүүлэлтэд гарч байгаа ахиц дэвшлийг үргэлжлүүлэх нь туйлын чухал юм. Макро эдийн засгийн эрүүл бодлогыг банкны системийн бүтцийн шинэчлэлтэй хослуулах нь хүүгийн хувийг аажмаар буулгахад нэмэр болно.”

“Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн дөрөв дэх үнэлгээний эцэст ОУВС-гийн ажлын хэсэг эрх баригчидтай ажлын хэсгийн түвшинд тохиролцоонд хүрлээ. Энэхүү тохиролцоо нь ОУВС-гийн Захирлуудын зөвлөлөөр хэлэлцэгдэн баталгаажих учиртай.

“Ажлын хэсгийг Монгол улсад байх хугацаанд хамтран ажиллаж, бүтээлч яриа хэлэлцээ өрнүүлэн, зочлон хүндэтгэсэн эрх баригчдад талархал дэвшүүлье.”

[1] Доллараар илэрхийлэх дүнг 2017оны 5-р сарын 24-ний өдрийн ЗТЭ-ийн доллартай харьцах ханшаар тооцох бөгөөд энэ нь 2017 оны 2-р сарын 27-ны өдрийн ЗТЭ-ийн доллартай харьцах ханш буюу 1.35274-өөр тооцсон 425 сая доллар байна.